

ГОВЬСҮМБЭР АЙМГИЙН 2021 ОНЫ 6 ДУГААР САРЫН ЦАГ ҮЕИЙН МЭДЭЭ

НЭГ. УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ХҮРЭЭНД

Аймгийн Удирдах ажилтны шуурхай зөвлөгөөнийг 2 удаа зохион байгуулж, нийт 4 үүрэг даалгавар өгч, хэрэгжилтийг ханган ажилласан. Засаг даргын зөвлөлийн хурал 1 удаа зохион байгуулж, 5 асуудал хэлэлцэж шийдвэрлэсэн.

Монгол Улс Азийн Хөгжлийн Банкнд гишүүнээр элссэний 30 жилийн ойн хүрээнд зохион байгуулж буй бүсийн цуврал уулзалт-хэлэлцүүлэг Өмнөговь, Дорноговь, Дундговь болон Говьсүмбэр аймгуудыг хамарсан Говийн бүсийн арга хэмжээгээр эхэллээ.

Уулзалт хэлэлцүүлгийн хүрээнд Говьсүмбэр аймаг болон бусад оролцож буй аймгуудад хэрэгжиж буй төслүүдийн үр дүн, нийгэм, эдийн засгийн хөгжилд үзүүлж буй үр нөлөөтэй танилцав. Төсөл хэрэгжүүлэгч байгууллагуудыг төлөөлөн Барилга, хот байгуулалтын яам, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам, Эрүүл мэндийн яамны Төрийн нарийн бичгийн дарга нар оролцож, төслийн үр өгөөж болон Монгол улсад цаашид хэрэгжих боломж нөхцөлийн талаар санал солилцлоо.

Коронавирус /ковид-19/-ийн цар тахлын хүрээнд:

“Коронавируст халдвар /ковид-19/-ын эрсдэлээс урьдчилан сэргийлэх хариу арга хэмжээ авах тухай” аймгийн Засаг даргын 2021 оны 06 дугаар сарын 17-ны өдрийн А/172 дугаар захирамжаар улбар шар түвшинд шилжин ажиллаж байна. Нийт халдварын тоо 371, эдгэрсэн 232, эмчлэгдэж байгаа 138 иргэн байна. Гэрийн ажиглалтад 169 иргэн байгаад хяналт тавин ажиллаж байна.

Коронавируст халдвар (Ковид-19)-ын эсрэг дархлаажуулалтын үйл ажиллагааг аймгийн хэмжээнд 4 түр цэг, 2 явуулын багаар зохион байгуулан ажиллаж байна. ХӨСҮТ-өөс Синофарм үйлдвэрлэгчийн Вероцелл вакцин, Пфайзер үйлдвэрийн Комернити вакциныг нийт 22571 хүн тунг татан авч 90.2 хувийг зарцуулаад байна. Вакцины I тунд тус аймагт бүртгэлтэй 18-аас дээш насны 11197 ирэн, II тунд тус аймагт бүртгэлтэй 18-аас дээш насны 9974 иргэн хамрагдаад байна. Пфайзер үйлдвэрийн Комернити вакцинд 12-18 насны 1858 хүүхэд хамрагдаад байна.

Засгийн газрын 2021 оны 118 дугаар тогтоол, Улсын Онцгой комиссын даргын 2021 оны 41 дүгээр тушаалаар батлагдсан “Коронавируст халдвар (Ковид-19)-аас сэргийлэх арга хэмжээг зохион байгуулах түр журам”, аймгийн Засаг даргын 2021 оны 06 дугаар сарын 02-ны А/162 дугаар захирамжийн хэрэгжилт, түр журмын тусгай нөхцөл, шаардлагыг хангуулахаар эрүүл ахуй, халдвар хамгаалал, хүнсний чанар, стандартын хяналтаар үйл ажиллагааг хязгаарлаагүй бүх чиглэлийн худалдаа, үйлчилгээний байгууллага, хоол үйлдвэрлэл эрхэлж байгаа 23 объектыг хамруулан хяналт шалгалт хийж 43 зөрчил илрүүлж, зөрчлийн 33 буюу 77 хувийг газар дээр нь арилгуулж, 2 ААНБ-д 10 заалт бүхий Улсын байцаагчийн хугацаатай албан шаардлагыг хүргүүлэв. Албан шаардлагын хэрэгжилт 80 хувьтай байна.

Мөн халдвар хамгааллын дэглэм зөрчсөн 1 ААНБ-ын үйл ажиллагааг зөрчил арилгах хүртэл түр зогсоов.

Шалгалтад хамрагдсан нийт объектуудад зөрчлийг давтан гаргахгүй байх, халдвар хамгааллын дэглэмийг чанд сахиж ажиллах талаар үүрэг өгч тухайн чиглэлийн үйл ажиллагаанд тавигдах тусгай нөхцөл шаардлагын талаар зөвлөмжийг хүргүүлсэн.

Коронавируст халдвар /КОВИД-19/-ын дархлаажуулалтад иргэдийг хамруулах ажлын хүрээнд ХӨСҮТ-өөс Аймгийн Эрүүл мэндийн газрын агуулахад тээвэрлэгдэн ирсэн Пфайзер үйлдвэрийн Комирнэти 2292 тун вакцины тээвэрлэлт, хадгалалт, сав баглаа боодлын аюулгүй байдал, эрүүл ахуйн дэглэм шаардлагын стандартад холбогдох хяналтын улсын байцаагч хяналт шалгалт хийж, мэргэжил арга зүйгээр ханган ажиллаж байна. /Аймгийн нэгдсэн эмнэлгийн хуучин байрны Лабораторийн хэсэгт Пфайзер үйлдвэрийн Комирнэти вакцинаар дархлаажуулж буй байдалд хяналт хийсэн.

Коронавирусийн халдвар батлагдсан үед эрүүл мэндийн байгууллагуудын бэлэн байдал, эмнэлгийн тусламж үйлчилгээний чанар, аюулгүй байдлыг хангуулах үүднээс Аймгийн Нэгдсэн эмнэлэг болон Шивээговь сумын эрүүл мэндийн төвд тандалт судалгаа хийж мэргэжил арга зүйгээр ханган ажиллав.

ХОЁР. ЭДИЙН ЗАСАГ, ТӨСӨВ, САНХҮҮГИЙН БОДЛОГЫН ХҮРЭЭНД

Монгол Улсын Төсвийн тухай хуулийн хэрэгжилтийг хангах, орлого бүрдүүлэлтийг эрчимжүүлэн төсвийн орлогын төлөвлөгөөг жигд хангах биелүүлэхэд анхаарч ажиллаж байна.

2021 оны 6 дугаар сарын нийт татварын орлогын төлөвлөгөө 3 201 912.8 мянган төгрөг төвлөрүүлэхээс 3 786 088.5 мянган төгрөг төвлөрүүлж, 118 хувийн гүйцэтгэлтэй байна. Үүнээс улсын төсвийн орлогын төлөвлөгөө 545 262.6 мянган төгрөг төвлөрүүлэхээс 567 071.1 мянган төгрөгийг төвлөрүүлж 103 хувь, сумын төсвийн орлогын төлөвлөгөө 415 245 мянган төгрөг төвлөрүүлэхээс 454 981.9 мянган төгрөг төвлөрүүлж 109 хувь, аймгийн төсвийн орлогын төлөвлөгөө 2 241 405.2 мянган төгрөг төвлөрүүлэхээс 2 764 035.4 мянган төгрөг төвлөрүүлж 123 хувийн гүйцэтгэлтэй байна.

2021 оны 6 дугаар сарын 25-ны өдрийн байдлаар татвар төлөгч хуулийн этгээд нийт 642 болсон.

1 аж ахуй нэгжид 2017-2020 оны татвар, санхүүгийн баримт материал, татварын хяналт шалгалтын ажлыг зохион байгуулж 13 553 080 төгрөгийн нөхөн ноогдуулалтын акт үйлдэн ажиллалаа.

Санхүүгийн хяналт аудитын чиглэлээр: Төсвийн болон орон нутгийн өмчит 77 байгууллагын шилэн дансны хуулийн хэрэгжилтэд хяналт тавьж ажилласан. 2021 оны 5 дугаар сарын байдлаар шилэн дансны хуулийн хэрэгжилт 93.6 хувь буюу өмнөх сарын хэрэгжилтээс 2 хувиар буурсан үзүүлэлттэй байна.

2021 оны эхний хагас жилийн төлөвлөгөөгөөр 9 байгууллагад хяналт шалгалт хийхээр төлөвлөснөөс төлөвлөгөөт 4, төлөвлөгөөт бусаар 7 хяналт шалгалт хийсэн. Шалгалтаар нийт 57 413.3 мянган төгрөгийн зөрчил илрүүлснээс 8 140.8 мянган төгрөгийг орон нутгийн орлого болгуулахаар, 1 913.0 мянган төгрөгийг хувь хүнд нь буцаан олгуулахаар улсын ахлах байцаагчийн нөхөн төлбөрийн акт тогтоов. Актын барагдуулалт 90.3 хувьтай байна.

Нийгмийн даатгалын сангаас олгосон: Тэтгэвэр

№	Төрөл	2020.06.25		2021.06.25	
		Хүний тоо	Тэтгэврийн дүн /мян, төг/	Хүний тоо	Тэтгэврийн дүн /мян. төг/
1	Өндөр настан	1796	4583576.4	1917	5339290.1
2	Хөгжлийн бэрхшээлтэй	339	743416.6	305	629289.6
3	Тэжээгчээ алдсан	126	233647.6	121	247495.2
4	Үйлдвэрийн осол	27	88086.2	46	145302.4
Нийт дүн		2288	5648726,8	2389	6361377.3

Нийгмийн даатгалын сангаас олгосон: Тэтгэмж

№	Төрөл	2020.06.25		2021.06.25	
		Хүний тоо	Тэтгэмжийн дүн /мян.төг/	Хүний тоо	Тэтгэмжийн дүн /мян.төг/
1	ХЧТА тэтгэмж	568	76613.1	418	54615.7
2	ЖБА тэтгэмж	197	327159.3	220	414122.5
3	Оршуулга	31	31000	36	36000
4	ҮОМШӨ-ХЧТА	3	4521.5	14	13024.8

5	Ажилгүйдэл	225	238863.7	98	189580.8
	Нийт дүн	1024	678157.6	786	707343.8

Сайн дурын даатгал:

Сайн дурын даатгалын хамрагдалт	2020.06.25	2021.06.25
Шинээр	126	197
Мөнгө тушаасан	404	492
Тушаасан мөнгөн дүн / мян төг/	66168,9	95926,4

ГУРАВ. ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН БОДЛОГЫН ХҮРЭЭНД

Архивын баримтыг цахим хэлбэрт шилжүүлэх ажлын хүрээнд 400 заалт, 11910 хүний нэр, 169 байгууллагын нэр, 1693 газар зүйн нэр, 451 хуудас баримт программд холбосон. Архивын баримтаас 15 иргэнд лавлагаа мэдээлэл олгох үйлчилгээ үзүүлсэн.

Аймгийн Төрийн Архивын тасгаас Архив албан хэрэг хөтлөлтийн тухай хуулийн шинэчилсэн найруулгаар аймгийн Засаг даргын Тамгын газар, сумдын Засаг даргын Тамгын газар, Сүмбэр сумын 5 дугаар цэцэрлэг зэрэг байгууллагын албан хаагчдад танхимаар болон цахимаар сургалт зохион байгуулсан. Мөн 2021 оны Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуультай холбоотойгоор аймаг, сум, хэсгийн хороодод Сонгуулийн баримт бичгийг бүртгэх, хүлээн авах талаарх сургалтыг тус тус зохион байгуулсан.

Иргэний бүртгэлийн чиглэлээр:

- Шинээр гадаад паспорт захиалсан - 14
- Иргэний үнэмлэх шинээр олгосон - 46
- Төрснөө бүртгүүлсэн хүүхдийн тоо - 24
- Гэрлэлт бүртгүүлсэн тоо - 9
- Нас барсныг бүртгүүлсэн тоо - 3
- Өөр аймаг, хотоос шилжиж ирсэн нийт иргэн - 21
- Аймаг дотор шилжсэн иргэдийн тоо – 4

Эд хөрөнгийн бүртгэлийн чиглэлээр:

- Үл хөдлөх хөрөнгийг анхны удаа баталгаажуулах бүртгэл - 9
- Газар өмчлөх эрхийг анхны удаа баталгаажуулах бүртгэл - 14
- Гэрээний бүртгэл - 117
- Барьцааны гэрээний бүртгэл - 306
- Эд хөрөнгөд орсон өөрчлөлт, залруулга - 4

Хуулийн этгээдийн бүртгэлийн чиглэлээр:

- Шинээр байгуулагдсан хуулийн этгээдийн бүртгэл - 3
- Хуулийн этгээдийн бүртгэлийн өөрчлөлт - 4

Архивын чиглэлээр:

- Хуулийн этгээдэд гаргасан лавлагаа, хуулбар - 24
- Иргэнд гаргасан лавлагаа, хуулбар - 78

Нийт 680 иргэнд төрийн үйлчилгээг үзүүлсэн.

Цагдаагийн хэлтэс нь: 2021 оны 06 дугаар сард иргэд, аж ахуйн нэгж байгууллагаас нийт 118 гомдол, мэдээллийг хүлээн авч шалгаснаас гэмт хэргийн 32, зөрчлийн 86 гомдол байна.

Аймгийн Засаг даргын 2021 оны 6 дугаар сарын 13-ны өдрийн “Урьдчилан сэргийлэх арга хэмжээ авах тухай” А/168 дугаар захирамж болон 2021 оны 6 дугаар сарын 17-ны өдрийн “Коронавируст халдвар /Ковид-19/-ын эрсдлээс урьдчилан сэргийлэх хариу арга хэмжээ авах тухай” А/172 дугаар захирамжийн дагуу гамшгаас хамгаалах өндөржүүлсэн бэлэн байдлын 3

дугаар зэрэгт шилжин ажиллаж, Улаанбаатар хот болон халдварын голомт бүс нутгаас хүндэтгэн үзэх шалтгаанаас бусад тохиолдолд иргэд, тээврийн хэрэгслийн орох, гарах хөдөлгөөнийг хязгаарлах, аймгийн төв, сум хооронд зөвшөөрлийг үндэслэн хөдөлгөөнд оролцуулах, авто замын шалган нэвтрүүлэх цэгийг нэмж байгуулан, иргэд, тээврийн хэрэгслийн хөдөлгөөнд тавих хяналтыг чангатгах, захирамжид заасан хугацаанд сул болон өндөр агууламжтай архи, согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэхийг хориглох, худалдаа, үйлчилгээний байгууллагуудын ажиллах цагийн хуваарьт хяналт тавих, иргэдээс Замын цагдаагийн шалган нэвтрүүлэх хяналтын цэгээр нэвтрэхэд нь түргэвчилсэн тестийн шинжилгээг төлбөртэйгээр авч, хариуг үндэслэн нэвтрүүлэх зэрэг ажил, арга хэмжээг зохион байгуулан ажиллаж байна.

Тайлант хугацаанд зөрчил гаргасан 2711 иргэнийг эрх бүхий албан тушаалтнаас болон шүүхээс 99460000 төгрөгөөр торгож, согтуугаар зөрчил гаргасан 79 хүнийг эрүүлжүүлж, 16 хүнийг шүүхээр баривчлуулан, согтуугаар тээврийн хэрэгсэл жолоодсон 21 жолоочийн тээврийн хэрэгсэл жолоодох эрхийг хассан байна.

Хариуцсан нутаг дэвсгэрийн эрүү, хэв журмын нөхцөл байдалд дүн шинжилгээ хийж, цар тахлаас урьдчилан сэргийлэх ажлыг эрчимжүүлэх зорилгоор үйл ажиллагаа явуулж байгаа худалдаа, үйлчилгээний давхардсан тоогоор 111 цэгийн халдвар хамгааллын дэглэм сахиулж буй байдалд өдөр тутам хяналт шалгалт хийж, зөвлөгөө өгч ажиллав.

Камерын хяналтыг тогтмол ажиллуулснаар гэрэл дохио, зогсох, зогсоолын журам зөрчсөн 3 зөрчил

Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлыг цахим хэлбэрээр олон нийтэд хүргэх, хууль сурталчилах, ухуулах, цаг үеийн болон нөхцөл байдлын талаарх мэдээ мэдээллийг түгээх ажлыг тасралтгүй зохион байгуулж, байгууллагын вэб хуудасны мэдээллийг шинэчлэн, "Говьсүмбэр аймаг дахь цагдаагийн хэлтэс" пэйж хуудас болон фэйсбүүк хуудсанд постер 105, зурагт мэдээлэл 26, видео 33, санамж сэрэмжлүүлэг зөвлөмж 94 ширхэгийг тус тус иргэд олон нийтэд хүргэсэн.

"Хот айл" аян, "Хүүхдэд ээлтэй жолооч" нэгдсэн арга хэмжээ, Насанд хүрээгүй хүүхдийн хөдөлмөр эрхлэлтийг илрүүлэх, хүүхдийн эрхийн зөрчлийг илрүүлэн хүүхэд хамгааллын хариу үйлчилгээ үзүүлэх зорилгоор "Хүүхэд эрсдэл" хэсэгчилсэн арга хэмжээг зохион байгуулж ажилласан.

Шүүхийн шинжилгээний алба нь: Хэргийн газрын үзлэгт 13 удаа оролцсоноос зам тээврийн ослын 5, хулгайлах гэмт хэрэг 2, бусад хэргийн газрын үзлэгт 6 удаа, хэргийн газрын үзлэгийн болон эд мөрийн баримт, эрэн сурвалжлах, танин олуулах ажиллагаа, хэргийн газрын давтан үзлэг, нэгжлэг, цогцос задлан шинжлэх зэрэг ажиллагааны 279 кадр гэрэл зургийг боловсруулан холбогдох материалд хавсаргасан.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар 425 дугаар нээлттэй хорих анги нь: Ангийн үйлдвэрлэлд түшиглэн хөдөлмөрийн дадал олгох сургалтанд 8 хүмүүжийг хамруулж байна.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын 100 жилийн ойг тохиолдуулан Морин хуурын дугуйланд 10 хүмүүжигчийг сургагч багшаар бэлтгэн 100 морин хуурчийг бэлтгэх ажлыг эхлүүлсэн. Гитарын дугуйланд 9 хүмүүжигч суралцаж байна.

2021 оны 6 дугаар сард төлбөрийн 174 гүйцэтгэх баримт бичгийн 2667615.6 төгрөг төвлөрүүлэхээс 43 баримт бичгийн 363456.2 мянган төгрөг төвлөрүүлж, бодит биелэлт 30.2 хувьтай байна.

Мэргэжлийн хяналтын газар нь: Сүмбэр сумын 1 дүгээр баг, үйлдвэрлэлийн бүсэд үйл ажиллагаа явуулж буй аж ахуй нэгжүүдийн үйл ажиллагаанд хамтарсан хяналт шалгалтыг хийж байгаль орчны тухай хууль тогтоомж зөрчсөн 3 ААНБ, 1 иргэнд Зөрчлийн тухай хуулийн дагуу 7.8 сая төгрөгийн торгуулийн арга хэмжээ ногдуулсан. Хяналт шалгалтын ажил үргэлжилж байна.

Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын даргын баталсан төлөвлөгөөт болон төлөвлөгөөт бус шалгалтын удирдамж, улсын Онцгой комисс, аймгийн Онцгой комиссоос өгсөн үүрэг даалгавар, иргэд, ААНБ-аас ирүүлсэн гомдол, мэдээллийн дагуу нийт 15 хяналтын чиглэлээр төлөвлөгөөт болон төлөвлөгөөт бус шалгалтыг хийж Улсын байцаагчийн албан шаардлага 15, дүгнэлт 6, зөвлөн туслах үйлчилгээний хөтөлбөр 5-ыг тус тус боловсруулж, хяналт шалгалтад хамрагдсан иргэн, ААНБ-уудад хүргүүлэв.

Хүнсний чанар, стандартын хяналтын улсын байцаагч, эрүүл ахуй халдвар хамгааллын хяналтын улсын байцаагч болон аж ахуй нэгж байгууллага, иргэний хүсэлтээр ирүүлсэн усны 12, хүнсний бүтээгдэхүүний 26, ариутгалын бодисын 6 нийт 44 сорьцод 174 үзүүлэлтээр хими, нян судлалын шинжилгээг гүйцэтгэсэн. Эерэг үзүүлэлт 9 илэрсэн.

Онцгой байдлын газар нь: Онцгой байдлын ерөнхий газар болон Цаг уур орчны шинжилгээний газраас ирүүлсэн цаг агаарын сэрэмжлүүлэг мэдээ 2, Онцгой байдлын газрын үйл ажиллагааны чиглэлээр 21, Коронавируст халдвар (КОВИД-19)-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх сэрэмжлүүлэг 46 мэдээг олон нийтийн сүлжээгээр мэдээллэсэн.

2021 оны 6 дугаар сарын 1-4-ний өдрүүдэд Сүмбэр сумын нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулдаг хүүхэд хамгааллын байгууллагат гүйцэтгэлийн шалгалт, ерөнхий боловсролын 1, 2, 3, 5 дугаар сургуулийн спорт заал, хөдөөгийн 4, 5, 6 дугаар багийн сонгуулийн хэсгийн хороодод Цагдаагийн хэлтэс, Тагнуулын хэлтэс, Цахилгаан шугам сүлжээ, Мэргэжлийн хяналтын газартай хамтран төлөвлөгөөт хяналт шалгалтыг зохион байгуулж, Гал түймрийн улсын хяналтын байцаагчийн заавал биелүүлэх албан шаардлага 1, мэдэгдэл 9-ийг тус тус бичиж холбогдох албан тушаалтанд хүргүүлсэн.

УБТЗ-ын ус хангамжийн 2 дугаар ангийн харьяа Чойр цахилгаан цахилгаан шугам сүлжээний 2021 оны 06 дугаар сарын 03-ний өдрийн Онцгой байдлын газарт ирүүлсэн хүсэлтийг шийдвэрлэн тусгай зориулалтын халаагуурыг галлаж хөлдүүсийг гаргах, галын аюулгүй байдлыг ханган ажиллах чиглэлээр гал түймрийн улсын хяналтын байцаагчийн мэдэгдэл хүргүүлсэн.

Сүмбэр сумын 1, 3 дугаар багийн нутагт байрлах “Гор газ” ХХК-ны ШТС, “Магнай трейд” ХХК 79, 104 ШТС-ын салбар, “Сүлд хүнсний дэлгүүр”, иргэн Т.Баянцогтын явуулын автоцистерн”, “Сүмбэр үйзэн оргил хүнсний дэлгүүр”, “Хүүхэд гэр бүл залуучуудын төв”-үүдын галын аюулгүй байдлыг шалгаж мэргэжил арга зүйн зөвөлгөө өгч ажилласан.

Тайлант хугацаанд аймгийн хэмжээнд гал түймрийн объектын дуудлага 2 удаа бүртгэгдсэн.

ДӨРӨВ. БОЛОВСРОЛ, СОЁЛ, ЭРҮҮЛ МЭНД, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН БОДЛОГЫН ХҮРЭЭНД

Боловсролын чиглэлээр: 2020-2021 оны хичээлийн жилийн суурь, бүрэн дунд боловсролын төгсөгчдийн гэрчилгээг Боловсролын мэдээллийн сангийн цахим программаас хэвлэж, нийт 528 гэрчилгээг төгсөгчдөд олгон, хуулбарыг цаасаар архивлан 1 хувийг Боловсрол, Шинжлэх ухааны яамны Ерөнхий боловсролын газарт хүргүүлсэн.

МУБИС-ийн физикийн багштай гэрээ байгуулан физикийн хичээлээр элсэлтийн ерөнхий шалгалт өгөх төгсөгчдөд 10 цагийн онлайн давтлага зохион байгуулж, давхардсан тоогоор 185 суралцагч хамрагдлаа.

Хэлний бодлогын үндэсний зөвлөлтэй хамтран “Монгол бичгийн үндэсний Хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэх асуудал 1000 багшийн сургалтад аймгийн Монгол хэл, уран зохиолын 16 багш хамрагдан шинэ арга барил, мэдээлэл эзэмшсэн. Мөн “Хүүхдийн эх хэлний боловсрол” эрдэм шинжилгээний хуралд сургуулийн өмнөх боловсролын 24 багш оролцож, бага насны хүүхдийн тархины онцлог, заах арга зүйн талаар мэдлэг эзэмшсэн. Үндсэн зурлага, эгшиг үсэг На, Ма, Ла сэдвээр цахим хичээл бэлтгэн, иргэдэд түгээсэн.

Хүүхдийн амралт эхэлсэнтэй холбоотой ахуйн осол, халдварт корона вирусээс сэргийлэх талаар 18 удаагийн цахим хуудас түгээж, 7550 иргэнд хүргэсэн.

Дэлхийн зөн олон улсын байгууллага болон Японы хүүхдийг ивээх сангийн сургагч багш нартай хамтран хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй ажилладаг багш нарыг мэргэшүүлэх, чадавхижуулах зорилгоор “Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй хэрхэн ажиллах вэ?” сэдэвт сургалтыг аймгийн хэмжээний 6 цэцэрлэг, 5 сургуулийн 64 багш, удирдах ажилтан, эцэг эхчүүд хамрагдсан.

Боловсрол, Шинжлэх Ухааны Яам, Шинжлэх Ухаан Технологийн Их Сургуультай хамтран Ерөнхий боловсролын сургууль, дотуур байр, цэцэрлэгийн нярав, эмч, тогооч нарт зориулсан мэргэшүүлэх сургалтыг зохион байгуулсан. Сургалтад нийт 39 албан хаагч хамрагдан, хүүхдийн хоолны стандарт, илчлэг тооцох аргачлал, хүүхдийн хоол бэлтгэх арга зүйгээс суралцсан.

“Бага насны хүүхдийн хөгжлийн чиг хандлага сургалтын арга зүй, технологийн хөгжил” И.Форум 2 өдрийн хэлэлцүүлэгт хувийн болон төрийн цэцэрлэгүүдийн удирдах ажилтан, багш нийт 42 хүн хамрагдлаа.

Гэр бүл, хүүхэд, залуучуудын чиглэлээр: Дэлхийн Зөн ОУБ-тай хамтран залуу хос, өрх гэр бүлүүдийн сайн сайхны төлөө тэдний харилцаа хандлага, гэр бүлийн хамтын амьдралын ойлголцлыг бэхжүүлэх, тэдний бүх талын хэрэгцээнд хайрын итгэлцлийг бий болгоход гэр бүлийг дэмжих, тогтвортой байдлыг хангах, хөгжүүлэх чиглэлээр үе шаттай сургалтыг орон нутгийн хэмжээнд зохион байгуулж байна. Энэ удаагийн сургалтаар 7 өрхийн 14 хос хамрагдсан. Сургалтын үр дүнд өрх гэр бүлийн тогтвортой байдлыг дэмжиж, хамтын амьдралын итгэлцэл, ойлголцлыг нэмэгдүүлж, эцэг эхийн үүрэг хариуцлагыг ухамсарлуулж, гэр бүлийн боловсролыг ойлголттой болсон.

Соёл, урлагийн чиглэлээр: Олон улсын Эх үрсийн баярын өдөрт зориулан “Гэгээн муза-15” Олон улсын театрын их наадмын шагналт “Эрэлхэг эльф маранта” хүүхдийн жүжгийг цахимаар хүүхэд багачуудад хүргэсэн.

Уншигч иргэд, хүүхэд багачуудад зориулан С.Пүрэвсүрэнгийн Нутгийн салхи, Ц.Дамдинсүрэнгийн Чөтгөр, Эцэг сургамжит өгүүллэг, Бадарчин, О.Дашбалбарын Талын чоно, Ногоон хаалга, Далайн гүнж зэрэг танин мэдэхүй, өгүүллэг тууж, яруу найраг, үлгэр зэрэг цахим номыг өөрийн сайт дээр тавьж, 1487 уншигчдад хүргэсэн. Цахим зөөврийн үйлчилгээ буюу шинэ номын мэдээллийг хөгжлийн бэрхшээлтэй 5 иргэн, 1 хүүхэдэд хүргэсэн. Цахимаар 25 иргэнд 32 төрлийн шинэ номын мэдээллийг хүргэсэн.

Музейн үйлчилгээг танхимаар 81 том хүн, 40 хүүхэд үйлчлүүлсэн. Явуулын VRBOX-оор музейн үйлчилгээг 35 Хөгжлийн бэрхшээлтэй иргэнд, байгалийн танхимын үзмэрүүдийг цахим дижиталд шилжүүлэн тайлбартайгаар цахимд байршуулан 956 иргэнд хүргэн үйлчиллээ.

Аймгаас төрөн гарсан гавъяатуудыг цуврал болгон цахимаар танилцуулан олон нийтэд сурталчлан таниулах, алдаршуулах ажлыг зохион байгуулж байна.

Монгол улсын Соёлын биет бус өвийн Уламжлалт баяр наадам, зан үйл, ёс заншил, тоглоом наадгай, уриа дуудлагын 44 өвийг байршуулан, цахимаар сурталчилсан.

Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд угийн бичиг хөтлөх анхан шатны сургалтыг цахимаар зохион байгуулж, 23 иргэн хамрагдсан.

Монгол бичгийн үндэсний хөтөлбөр -3 хэрэгжүүлэх ажлын хүрээнд Говьсүмбэр аймгийн 5-р сургуулийн сурагчийн “Амин гариг” Монгол бичгийн уран бичлэгийн үзэсгэлэн танхим болон цахимаар зохион байгуулагдаж, танхимаар 145 хүнд, цахимаар үзүүлэхэд 246 хүний хандалт авсан байна.

Спортын чиглэлээр: Засгийн газрын тохируулагч агентлаг биеийн тамир спортын улсын хорооноос зохион байгуулж байгаа “Дасгал хөдөлгөөн хийцгээе” идэвхтэй хөдөлгөөнийг дэмжих сарын аяныг 2021 оны 6 дугаар сарын 2-30-ны өдөр хүртэл зохион байгуулж байна. Тус аяны хүрээнд “Алхах-гүйх-Дугуй” үйл ажиллагаа явагдаж байна.

Эрүүл мэндийн чиглэлээр:

Үзүүлэлт	2020 оны 06 сар	2021 оны 06 сарын 20-ны байдлаар
Төрсөн эх	227	202
Гэрийн төрөлт	0	2
Амьд төрсөн хүүхэд	230	206
Амьгүй төрөлт	0	0
Нас баралт	36	31
Эмнэлгийн нас баралт	2	8
Хоног болоогүй нас баралт	0	4
0-1 хүртэлх насны хүүхдийн эндэгдэл	0	1
1-5 хүртэлх насны хүүхдийн эндэгдэл	2	0
Эмнэлгээс гарсан хүний тоо	2 418	1779
Амбулаторийн үзлэг	49 986	45 902
Халдварт өвчин	57	267

“Эрүүл мэндийн хөгжлийн төв”-ийн мэргэжилтэн, Эрүүл мэндийн хөгжлийн зуун ассиоциацийн гишүүн, ЭМДЕГ-ын дарга нарын бүрэлдэхүүнтэй баг ирж нэгдсэн эмнэлэгт ажиллаж гүйцэтгэлийн санхүүжилт, “Up to Date3” платформын талаарх зөвлөгөөг өглөө. Up to Date программын сургагч багш бэлтгэх сургалтад нэгдсэн эмнэлгийн 3 ажилтан хамрагдаж байна

Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний чиглэлээр: Ажил мэргэжлийн чиг баримжаа олгох ганцаарчилсан зөвлөгөө өгөх үйлчилгээнд 37 иргэнийг хамруулсан. Хагас жилийн байдлаар өссөн дүнгээр 162 иргэнд ажил мэргэжлийн чиг баримжаа олгох ганцаарчилсан зөвлөх үйлчилгээг үзүүлж, хөдөлмөр эрхлэлтийн бүртгэл мэдээллийн нэгдсэн санд бүртгэсэн.

Ажил олгогч аж ахуй нэгж байгууллагаас 60 сул, чөлөөтэй ажлын байрны захиалгыг авч, бүртгэлтэй ажил хайгч иргэдэд утсаар болон цахим мэдээллийн хэрэгслээр хүргэж, 22 иргэнийг байнгын ажлын байранд, түр ажлын байранд 34 иргэнийг зуучилж, ажилтай орлоготой болгосон.

Өссөн дүнгээр нийт 153 иргэнийг ажилд зуучлаад байна. Үүнд: Байнгын ажлын байранд 75 иргэн, түр ажлын байранд 66 иргэн, улирлын ажлын байранд 12 иргэн хамрагдсан.

25-аас дээш ажилтантай аж ахуйн нэгж байгууллагуудад Хөдөлмөрийн тухай хуулийн 111 дүгээр зүйлийн хэрэгжилтэд хяналт хийж, зохих төлбөрийг хөдөлмөр эрхлэлтийг дэмжих санд төвлөрүүлээгүй 12 аж ахуйн нэгж байгууллагын тайлбарыг албан бичгээр авч ажилласан. Орон нутагт 25-аас дээш ажилтантай 40 ААНБайгууллага байна. Үүнд: хуулийн хэрэгжилтийг бүрэн ханган хөгжлийн бэрхшээлтэй иргэн ажиллуулж буй 27 байгууллага, төлбөрөөс чөлөөлөгдсөн 1 аж ахуйн нэгж, хуулийн хэрэгжилтийг хангаагүй 12 байна.

2021 оны 6 дугаар сарын байдлаар нийгмийн халамжийн сангаас дараах хөнгөлөлт, үйлчилгээнүүдийг үзүүллээ. Үүнд:

- Нийгмийн халамжийн тэтгэвэр 253 хүнд 178.3 сая төгрөг
- Нөхцөлт мөнгөн тэтгэмж 252 хүнд 127.5 сая төгрөг
- Амьжиргааг дэмжих мөнгөн тэтгэмж 226 хүнд 98.4 сая төгрөг
- Ахмад настнуудад үзүүлсэн хөнгөлөлт, тусламж 499 хүнд 9.1 сая төгрөг
- Хөгжлийн бэрхшээлтэй хүнд үзүүлсэн хөнгөлөлт, тусламж 53 хүнд 7.0 сая төгрөг
- Хүнс тэжээлийн дэмжлэг туслалцаа 673 хүнд 43.0 сая төгрөг
- Олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээнд 18 хүнд 6.0 сая төгрөгийг тус тус зарцуулсан.

Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын салбар комиссын хурлыг 1 удаа зохион байгуулж, 2 хүүхдийг хөгжлийн бэрхшээлтэй болохыг сунгасан.

ТАВ. ХӨДӨӨ АЖ АХУЙН БОДЛОГЫН ХҮРЭЭНД

Малх отрын бүсэд 4 аймгийн /Дундговь, Өвөрхангай, Төв, Говьсүмбэр/ 76 өрхийн 80.1 мян.тол мал, отрын бүсийн гадна 80 өрхийн 62.2 мян.тол мал отроор байна.

Төллөвөл зохих 166173 эх малаас 140996 эх мал төллөж, 141320 төл гарсан. Үүнээс 124047 төл бойжиж, төллөлт 84.8 хувь, төл бойжилт 87.8 хувьтай байна.Төлийн хорогдол 17273, том малын хорогдол 22641 буюу оны эхний нийт малын 5 хувийг эзэлж байна.

Малын хорогдол өмнөх оны мөн үеэс 5.2 дахин нэмэгдэж, 3044 мал хээл хаяж, өмнөх оны мөн үетэй харьцуулахад 4.5 дахин их байна.

"Мал бүртгэлжүүлэлтийн аян зохион байгуулах тухай" ХХААХҮСайдын 2021 оны А-72 дугаар тушаалын хүрээнд малыг ялган тэмдэглэж, бүртгэлжүүлэх, бүртгэл мэдээллийн нэгдсэн сан бүрдүүлэх ажлыг сумдын Засаг даргын Тамгын газрын Хөдөө аж ахуйн тасаг, Мал эмнэлгийн тасаг болон Мал үржүүлэг технологийн ажил үйлчилгээний нэгжүүд хамтран гүйцэтгэж байна.

"Үржлийн малд үзлэг, ангилалт хийх, баталгаажуулах, цөм сүрэг бүрдүүлэх, ялган тэмдэглэж, бүртгэлжүүлэх ажлыг зохион байгуулах тухай" аймгийн Засаг даргын 2021 оны 06 дугаар сарын 02-ны өдрийн А/160 захирамжийн хүрээнд "Сүмбэр Хишигтэн Зоо" МҮТАҮНэгжтэй гэрээ байгуулан зохион байгуулж байна. 2021 оны одоогийн байдлаар:

Ангилалтад хамруулсан-4390

Цөм сүрэгт-1541 толгой

Үржлийн сүрэгт-2794

Хэрэгцээний сүрэгт-55

Шинээр ээмэглэсэн-1103

Энэ онд 19.1 га-д төмс, 21.5 га-д хүнсний ногоог тариалж, 190 тн төмс, 214.8 тн хүнсний ногоон хураан авахаар төлөвлөн ажиллаж байна. Аймгийн дүнгээр 19.1 га-д төмс, 20.1 га-д хүнсний ногоо, 9 га-д тэжээлийн ургамал, 0.07 га-д жимс, жимсгэнэ тариалсан байна.

Нийтийн эрүүл мэндийг дэмжих жилийн хүрээнд өрхийн тариалан эрхлэгчдийн тоо, үйлдвэрлэлийн хэмжээг нэмэгдүүлэх, төмс, хүнсний ногооны өрхийн хэрэгцээгээ хангах нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор "Өрхийн тариалан эрхлэлтийг дэмжье" аяны нээлтийг зохион байгуулсан. Нээлтийн үеэр аймгийн Орон нутгийн хөгжлийн сангаас хөтөлбөр, арга хэмжээний зардлаас 2.9 сая.төгрөгийн үнэ бүхий 3 төрлийн 300 ш суулгац, 2 төрлийн 2.1 тн төмс, хүнсний ногооны үрийг шинээр өрхийн тариалан эрхлэх хүсэлтэй 66 иргэнд өгч тарих технологи, хэрэглэх бордооны талаар зөвлөгөө өгч, 165 ш гарын авлага тараасан.

Аймгийн төвийн захууд, томоохон худалдааны төвүүдийн хүнсний бараа бүтээгдэхүүний үнийг өнгөрсөн сарын үнэтэй харьцуулан гаргасан 2021 оны 6 дугаар сарын үнийн мэдээ:

Зах зээлд худалдаалагдаж буй зарим хүнсний бараа бүтээгдэхүүний үнэ өнгөрсөн сараас 50-100 төгрөгөөр нэмэгдсэн үзүүлэлттэй байна. Тухайлбал: лууван /монгол/ 50 төгрөгөөр, төмс 50 төгрөгөөр нэмэгдсэн үзүүлэлттэй байна. Бусад бараа бүтээгдэхүүний үнэ тогтвортой байна.

№	Бараа бүтээгдэхүүн		Дээд үнэ төг	Доод үнэ төг	Өссөн буурсан /5-р сараас /
1	Үхрийн мах	Ястай	11000	10000	-
		Цул	13000	12000	-
2	Хонины мах	Ястай	9000	8500	-
		Цул	12000	11000	-
3	Адууны мах	Ястай	6500	6000	-
		Цул	8500	8000	-
4	Ямааны мах	Ястай	7000	6500	-
		Цул	9500	9000	-
5	Лууван	монгол	1900	1000	50
		хятад			
6	төмс	монгол	1400	850	50
		хятад			
7	Байцаа	монгол	2000	1800	-
		хятад			-
8	чинжүү	монгол	8500	7000	-
		хятад	7500	4500	
9	Манжин	монгол	2000	1500	
		хятад			-
10	Сонгино бөөрөнхий	Монгол	4000	1800	-
		Хятад	-	1400	-
11	Помидор	монгол	7500	5500	-
12	Өргөст хэмх	монгол	7500	6500	-
13	Элсэн чихэр	монгол	3000	2300	-
14	Будаа	Цагаан задгай кг	3000	2400	-
		Шар слава кг	3500	3000	-
		Гурвалжин будаа кг	3800	2200	-
15	Сүү	Задгай	3450	3000	-
		Сүү ХХК 0,5л			
		Сүү ХХК 1л	3200	2900	-
16	Тараг	Задгай	2200	2000	-
		Сүү ХХК 1л цөцгийтэй тараг	4800	3800	-
17	Талх	Чойр талх	1200	1150	-
18	Өндөг	Монгол	550	450	-
19	Алтан гурил тарианы	Задгай дээд	1520	1480	
		Задгай 1-р зэрэг	1210	1100	-
		Задгай 2-р зэрэг	1000	950	-
		Савласан д/дээд /	2400	2300	-
		Савласан дээд	2200	2100	-
		Савласан 1-р зэрэг	1400	1300	-
		Савласан 2-р зэрэг	1500	1450	-

20	Ургамлын тос	Олейна	5500	5200	-
		Алтан	4500	4500	-

ЗУРГАА. БАЙГАЛЬ ОРЧИН, ҮЙЛДВЭР, ҮЙЛЧИЛГЭЭ, ДЭД БҮТЦИЙН САЛБАРЫН БОДЛОГЫН ХҮРЭЭНД

Байгаль орчны чиглэлээр: Сум дундын ойн анги мод үржүүлгийн газрын хүлэмжид хайлаас, шар хуайс, голт бор, нохойн хошуу зэрэг мод бутыг үрээр тарьсан.

Улсын тусгай хамгаалалттай “Чойрын богд” ууланд нутагшдаг зэрлэг амьтдын тандалт судалгааг Сүмбэр сумын байгаль хамгаалагч Улсын тусгай хамгаалалттай “Чойрын богд” уулын байгаль хамгаалагч нар 2021 оны 6 дугаар сарын 20-28-ны өдрүүдэд хийсэн.

“Жорлонгоо өөрчилье” аяны хүрээнд Сүмбэр сумын 3 дугаар баг, шинэ суурьшлын бүсэд хашаа барьсан айл, өрхүүдэд хөрс бохирдуулдаг нүхэн жорлонгүй, стандартын болон эко жорлонтой болох тухай гарын авлага тарааж, зөвлөгөө мэдээлэл өгсөн.

Улсын болон орон нутгийн тусгай хамгаалалттай газруудын мэдээллийн санг цаасан болон цахим хэлбэрээр бий болгосон.

Ус бохирдуулсны төлбөрийн тухай хуулийн хэрэгжилтийг хангуулж шинээр 30 аж ахуйн нэгжид Хаягдал ус хаях, зайлуулах зөвшөөрлийг сумдаар дамжуулан олгож эхлээд байна. Эхний хагас жилийн байдлаар ус бохирдуулсны төлбөр болох 3.090.770 төгрөг орон нутгийн орлогод төвлөрөөд байна.

Иргэн, аж ахуйн нэгжээс ирүүлсэн хүсэлтийн дагуу 1 иргэнд худаг гаргах, цооног өрөмдөх зөвшөөрөл олгож, 1 аж ахуйн нэгжийн төсөлд Байгаль орчны нөлөөллийн ерөнхий үнэлгээ хийж, дүгнэлтийг хүргүүлсэн. 2021 онд хийгдсэн Байгаль орчны нөлөөллийн ерөнхий үнэлгээний дүгнэлтүүдийг байгаль орчны мэдээллийн сангийн eic.mn цахим санд оруулсан.

Газрын харилцаа, барилга, хот байгуулалт, хөрөнгө оруулалтын талаар:

Аймгийн хэмжээнд 2021 оны 6 дугаар сард 3.348.270 төгрөгийн газрын төлбөр төлөгдөөд байна. Үүнд: Сүмбэр сум 1.697.006 төгрөг, Шивээговь сум 1.604.200 төгрөг, Баянтал сум 47064 төгрөг төлөөд байна. Мөн газрын төлбөрийн 2020 оноос өмнөх өр төлбөрөөс 1.281.104 төгрөгийг барагдуулсан.

Улс орон нутгийн хөрөнгөөр хийгдэж байгаа ажлуудын материалаас дээж авч лабораторийн шинжилгээг орон нутагтаа хийж байгаа бөгөөд явган замын хавтан, даацын хавтан зэрэг нийт 36 ширхэг сорьцыг шинжилгээнд хамруулаад байна.

Аймгийн Засаг даргын 2021 оны 05 дугаар сарын 24-ний өдрийн А/155 дугаар захирамжийн дагуу “Сууц өмчлөгчдийн холбоо”-нд хяналт шалгалт хийхээр томилогдсон ажлын хэсэг “Бадрах 70” СӨХ-ны үйл ажиллагаанд хяналт шалгалт хийсэн.

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар аймгийн төвд Цагдаагийн хэлтсийн барилга угсралтын ажил 35 хувьтай, Сүмбэр сумын 640 хүүхдийн суудалтай сургуулийн барилга угсралтын ажил 85 хувьтай, Сүмбэр сум 2-р багийн гэр хорооллыг цэвэр усны шугамд холбох, Тэрэгтийн эх үүсвэрт өргөх станц, цэвэршүүлэх тоног төхөөрөмж тавих ажил 98 хувьтай тус тус хийгдэж байна.

Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 2020-2021 онд дамжин хийгдэж буй аймгийн төвийн гэрэлтүүлгийн ажил 90 хувьтай, Сүмбэр сумын 1-р багийн гадна авто зогсоолын ажил 100 хувьтай, Талын Илч ОНӨААТҮГазарт зуух худалдан авч суурилуулах ажил улсын комисс ажиллуулж, ашиглалтад хүлээн авсан. ах шатанд хийгдэж байна.

Сүмбэр сумын 2021 оны ОНХС-н хөрөнгө оруулалтын 56.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 7 ухаалаг худгийн тоног төхөөрөмж, шугам сүлжээний ажлыг “Баялаг говь” ХХК гүйцэтгэж, байнгын ашиглалтад хүлээлгэн өгсөн.

Барьцаа хөрөнгө суллах хамтарсан үзлэг шалгалтыг 3 ажилд хийж гүйцэтгэн ажилласан. Үзлэг шалгалтын дагуу “Цэргийн алдар хөшөө”-ний тохижилт, 5, 6 дугаар багийн төвийн

засварын ажил, мал угаах ванны засварын ажлуудыг сайжруулах засах чиглэл өгч, засварыг сайжруулсан үед барьцаа хөрөнгийг суллахаар шийдвэрлэн ажилласан.

Мөн байгууллагаас Сүмбэр сумын 1 дүгээр багт баригдаж буй “Энх-Билэг” эмнэлгийн барилга угсралтын ажилд үзлэг хийж албан шаардлага өгч ажиллалаа.

Барилга байгууламжийн зогссон, ашиглалтын шаардлага хангахгүй 7 барилгад үзлэг шалгалт хийж, 6 барилгад албан шаардлага хүргүүлсэн.

Худалдан авах ажиллагааны талаар Төсвийн ерөнхийлөн захирагчид 2021 онд нийт 5.275.988,8 мянган төгрөгийн төсөвт өртөг бүхий 24 бараа, ажил, үйлчилгээ худалдан авч хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс 20 тендер шалгаруулалтыг цахим хэлбэрээр зарласан байна.

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар нийт 2 ажил хийгдэхээр төлөвлөснөөс 2 ажил, Орон нутгийн хөрөнгө оруулалтаар нийт 15 ажил хийгдэхээр төлөвлөснөөс 12 Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар нийт 5 ажил хийгдэхээр төлөвлөснөөс 4 ажил Авто замын сангийн хөрөнгө оруулалт, Байгаль хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний зардлын оруулалтаар хийгдэх 2 ажил төлөвлөснөөс 2 ажлын тендер шалгаруулалтыг тус тус зарлан гүйцэтгэгчтэй гэрээ байгуулаад байна.

Зарлагдсан тендерийн урилгуудыг “Монголын үнэн” сонин, www.tender.gov.mn, govisumber.gov.mn сайтуудад тухай бүр нийтэлж, тендер шалгаруулалтыг 100 хувь цахим хэлбэрээр явуулж байна. Тендер шалгаруулалтын үр дүнг тухай бүрд нь цахим системд оруулсан.

ДОЛОО. СУМ ОРОН НУТГИЙН ТАЛААР

Баянтал сум: E-Mongolia цахим үйлчилгээний үйл ажиллагааг эрчимжүүлэхээр нөлөөллийг ажлыг цахим хэлбэрээр явуулж, сумын FACEBOOK хуудсанд байршуулж иргэдэд мэдээлэл хүргэж байна. Нийт 25 иргэн e-Mongolia системээр үйлчлүүлсэн.

“Энх агуулах сан” ТББ-тай хамтран мод бут тариалах, зүлэгжүүлэх ажил хийгдсэн. Үүнд: Сумын төвийн 152-154 дүгээр байрны урьд, ТЗ-ын 18 дугаар зөрлөг, 621-р км, 2 аж ахуй нэгж байгууллага, 30 иргэдтэй хамтран зүлэгжүүлэх ажлыг хийсэн. Нийт 1 га газар зүлэгжүүлэлт хийсэн

“Ногоон байгууламжийн усалгаа, арчилгаа”, “Ногоон байгууламжийн хашаа барих” нийтийг хамарсан ажилд хөдөлмөрийн насны, хөдөлмөр эрхлээгүй 8 иргэн түр ажлын байранд ажиллаж байна.

Шивээговь сум: Сумын 22 дугаар зөрлөгт 3 тохиолдолд батлагдсантай холбогдуулан хавьтал болон дам хавьталыг тогтоож тусгаарлан хаалгыг лацдах арга хэмжээ аван ажиллаж сумын Засаг даргын 2021 оны 06 дугаар сарын 20-ны өдрийн А/99 дугаар захирамжаар 22 дугаар зөрлөгийн иргэд, тээврийн хэрэгслийн хөдөлгөөнд 2021 оны 06 дугаар сарын 20-ны өдрийн 15:00 цагаас 06 дугаар сарын 28-ны өдрийн 06:00 цаг хүртлэх хугацаанд хэсэгчилсэн байдлаар хязгаарлалт тогтоон хяналт тавин ажиллаж байна.

Коронавирусын тохиолдол илэрсэнтэй холбогдуулан ариутгал халдваргүйтгэлийн ажлыг зохион байгуулж, нийт 860м2 талбай, 22-р зөрлөгт нийт 4 объектын 354м2 талбайд ариутгал халдваргүйтгэл хийсэн.

Мөн аймгийн Онцгой байдлын газартай хамтран сумын нийтийн эзэмшлийн талбай, орон сууц, хэр хорооллын гудамж, хүүхдийн тоглоомын талбай, аж ахуй нэгж байгууллагууд зэрэг 57 цэгийн 184000 м2 талбайд ариутгал халдваргүйтгэлийн ажлыг зохион байгуулсан.

Сумын Ерөнхий боловсролын сургуульд нийт 798 сурагч суралцан төгсөж байгаагаас Суурь боловсролыг 44 сурагч, бүрэн дунд боловсролыг 32 сурагч, бага боловсролыг 73 сурагч төгсөж байна.

“Энх агуулга” ТББ-тай хамтран "Иргэдийн оролцоотой ногоон сумыг байгуулах" төсөлд хамрагдсан 34 иргэнд мод бут тарих аргачлалын талаарх сургалтыг зохион байгуулж мод тарих 5 төрлийн багаж хэрэгсэлийг олгосон.

Боом өвчнөөс урьдчилан сэргийлэх вакцинд 2369 толгой мал, ДХХ-интер бактериозоос хам сэргийлэх вакцинд 3954 толгой мал, туулгалтанд 12807 толгой мал, боловсруулалтанд 4782 толгой малыг тус тус хамруулаад байна.

Орчны бохирдлоос шалтгаалсан халдварт өвчлөл тархах эрсдлээс урьдчилан сэргийлэх зорилгоор сэг зэм устгалын ажлыг 6 дугаар сарын 5,6-ны өдрүүдэд зохион байгуулж, нийт 862 сэг зэмийг 4 цэгийн 124м² талбайд халдваргүйжүүлэлт хийж булж устгасан.

Соёлын төвд “Шаардлагатай тоног төхөөрөмж” худалдан авах шууд худалдан авалтын ажлын гүйцэтгэгчээр “Мандала Про Аудио” ХХК-ийг сонгон шалгаруулж 10 сая төгрөгийн гэрээг байгуулсанаар 8 нэр төрлийн тоног төхөөрөмжийг хүлээн авсан.

Сүмбэр сум: Сумын шуурхай штабаас хүнс тээвэрлэх, гэртээ харих, эрүүл мэнд, ар гэрийн гачигдлаар гэх мэт шалтгаанаар 81 автомашин, 334 иргэнд Улаанбаатар хотруу, 227 автомашин, 518 иргэнд бусад аймаг, орон нутагруу явах зөвшөөрлийг тус тус олгосон.

Сумын хэмжээнд гэрийн ажиглалтанд 355 иргэн байна.

2021 оны 2 дугаар сарын 8, 9-ний өдрүүдэд аймгийн нөөцөөс тус суманд хуваарилагдсан 3000 боодол өвсийг малчдад олгох ажлыг зохион байгуулан, 2400 боодол өвсийг тус бүр 8000 төгрөгөөр 240 малчин өрхөд олголоо.

Сумын хэмжээний гэр оронгүй иргэдийн судалгааг шинэчлэн гаргасан бөгөөд өмнөх онтой харьцуулахад гэр оронгүй иргэдийн тоо 3-аар өссөн байна. Дэлхийн Зөн ОУБ Бор-Өндөр 1 ОНХөтөлбөрт гэр оронгүй 7 өрхийн гэр хүссэн өргөдлийг хүргүүлснээс 5 өрхөд гэр олгохоор шийдвэрлэсэн.

“Маскаа зүү, гараа угаа” аяны хүрээнд амьдралын баталгаажих түвшнээс доогуур орлоготой 10 өрхийн хүүхдэд короно вирусээс урьдчилан сэргийлэх талаарх зөвлөмж, маск зүүж, гар угаах дадал олгох сургалтыг эрүүл мэндийн газартай хамтран зохион байгуулж, гар угаах болон дархлаа дэмжих багцыг олгосон.

Сум хөгжүүлэх сангаас зээл аваад хугацаандаа зээлээ төлж барагдуулаагүй болон чиглэлийн дагуу үйл ажиллагаа явуулаагүй 9 иргэнд сумын Засаг даргын төлбөр төлж барагдуулах тухай хугацаатай албан бичгийг хүргүүлсэн. Үүний дагуу 1 зээлдэгч 12.5 сая төгрөгийн зээлийг бүрэн төлж барагдуулсан байна.

ГОВЬСҮМБЭР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР